

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2022 оны... дугаар сарын... ны өдрийн
 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



**ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ
 БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:	
Шалгуулагч этгээдийн нэр:	
Регистрийн дугаар:	
Объектын нэр, хаяг, солбицол:	
Байгуулагдсан огноо:	
Үйл ажиллагааны чиглэл:	
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:	

2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Тайлбар	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Тийм	Үгүй		
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн эсэх.				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх.				
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн				

		хангасан эсэх.				
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.9	гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу хийлгэсэн эсэх.				
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх.				
Галын аюулгүй байдлын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, стандартын норм нормативын хэрэгжилт						
1		2.2.1. Нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц;				
2		2.14. Гал унтраах автомашин явах зам, гарцыг түр хугацаагаар хаах шийдвэр гаргасан албан тушаалтан энэ талаар тухайн төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагад мэдэгдэж, зам, гарцыг хаасан хугацаанд тойрч гарах замын чиглэлийг зааж, саадыг даван гарах боломжоор хангаж, усны эх үүсвэрт хүрэх гарцыг гаргасан байна.				
3	МУ-ын Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоол "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"	2.17. Барилга байгууламжийг түрээслэх гэрээнд тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах шаардлага, хариуцлагын талаар заавал тусгана.				
4		2.19. Барилга байгууламжийн аврах зам, гарцыг тухайн барилгад байрлах хүний тоог харгалзан төлөвлөж, аврах зам, гарцын өргөний хэмжээг аврах ажиллагаа явуулах хугацааны шаардлагыг хангахуйц байдлаар тогтооно.				
5		2.26. Түлшээр цэнэглэх халаагч, гэрэлтүүлэгч хэрэгслийг өөр төрлийн шатах шингэнээр (бензин, спирт г.м) цэнэглэхийг хориглоно.				
6		2.27. Тос, шатах шингэн болсон ажлын хувцсыг тусгайлсан газарт байрлуулсан металл шүүгээнд өлгөж хадгалдаг эсэх.				

7

2.35.4. Зоорийн болон хагас зоорийн давхарт дүрмээр зөвшөөрөгдснөөс бусад шатамхай болон хялбар авалцан асах шингэн, дарь, тэсэрч дэлбэрэх бодис, материал, хийн баллон зэрэг галын аюултай бодис, материалыг хадгалах, хэрэглэдэг эсэх.

8

2.35.9. Барилгын дотор зохион байгуулалт, өрөө тасалгаа, байр байршлын өөрчлөлт хийснээр хүмүүсийг аврах үйл ажиллагаа удаашрах, гал түймэр унтраах багаж хэрэгсэл, усан хангамжид хүрэх бололцоо хумигдах, гал унтраах автомат төхөөрөмжийн унтраах талбай багасах тохиолдолд барилгын дотоод засвар, өөрчлөлт хийх

9

2.2.1. Нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц.

10

Зоорь ба хагас зоорийн давхарт тусгайлан авч үзсэнээс бусад нөхцөлд шатамхай хий ба шингэн мөн хялбар авалцан асах материал агуулдаг буюу хэрэглэдэг өрөө тасалгаа байрлуулахыг зөвшөөрөхгүй

"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02-ийн 6.9 дэх заалт 7.7 дахь заалт

11

Авран хамгаалах ба аврах гарцын байдал холбогдох шаардлага хангасан эсэх
Гарцыг дараах нөхцөлд аврах зориулалттай гэж тооцно.
a) Нэгдүгээр давхрын өрөөнөөс гадагш гарах:
- шууд гарах
- коридор дамжиж гарах
- гонх хөлийн өрөөл- өөр дамжиж гарах
- шатны хонгилоор дамжиж гарах
- коридор ба шатны хонгилоор дамжиж гарах
б) Нэгдүгээр давхраас бусад аль ч давхрын өрөөнөөс:
- шатны хонгилд буюу 3-р төрлийн шатанд шууд гарах

12	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	Тухайн барилга байгууламжид гал унтраах автомат тоног төхөөрөмж төлөвлөгдсөн эсэх,	- усны насос, усан сангийн байнгын ажиллагаа хэвийн эсэх -Удирдлагын зангилааны ажиллагаа хэвийн эсэх				
13	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	Галын дохиоллын хэрэгсэл төлөвлөгдсөн эсэх мэдрэгч	-Утаа мэдрэгч -Дулааны -Удирдлагын самбар -гар мэдээлэгч				
14	Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-02-16/	Гал түймэр унтраах галын дотор болон гадна усан хангамж	-Гал унтраах хушуу -Галын хоолой -Холбох тотго -Барилгын гадна гидрант төлөвлөгдсөн эсэх				
15	Агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-02/-ийн 7 дугаар зүйл	Агаарын хаялт ба утаа зайлуулах системийн хэвийн ажиллагааг хангасан эсэх					
16	Гал түймрээс. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS5566:2020 стандарт	Тухай барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл стандартын дагуу байгаа эсэх.					
17	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143 : 2013	Энэхүү стандартын холбогдох заалтуудыг хангаж байгаа эсэх					
18	Эмнэлэгийн зориулалттай барилга төлөвлөх	Галын аюулгүй байдлын шаардлагууд байгууламжууд (корпусууд)					

	/БНБД 31-22-21/-ийн 7-р зүйл 7.1.1.	хооронд нь холбосон хүзүүвчийн хаших хийцийн галд тэсвэрлэх хязгаар нь холбогдож байгаа барилгуудын галд тэсвэрлэх хязгааруудаас багагүй байх ёстой. / БНБД 21-01-02 хүснэгт-4 /				
19		Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх зориулалттай дээвэртэй пандусын даацын ба хаших хийц нь тухайн барилгын шатны галд тэсвэрлэх хязгаартай ижил байна. / БНБД 21-01-02 хүснэгт -4 /				
20		Эмчлүүлэгсэд байнга байрладаг эмнэлгийн барилга, байгууламжид галын аюулын ГҮ ангид хамаарах гадна дулаалгын системийг хэрэглэнэ. / БНБД 21- 01-02: хүснэгт-4, Анги Ф1 1				
21		Хөлийн өрөө, шатны хонгил ба цахилгаан шатны үүдний өрөөний хана ба таазны дотор засал чимэглэлд галын аюулын ШҮ ангиллаас, нийтийн хонгил, холл, фойений хана, таазны засал чимэглэлд Ш1 (бага зэрэг шатдаг) ангиллаас;				
22		Хөлийн өрөө, шатны хонгил ба цахилгаан шатны үүдний өрөөний шаланд галын аюулын Ш1 ангиллаас, нийтийн хонгил, холл, фойений хана, таазны шаланд Ш2 (дунд зэрэг шатдаг) ангиллаас;				
23		Хагалгааны өрөө ба сэхээн амьдруулах палат (танхим)-ын хана болон таазны засалд галын аюулын Ш2 ангиллаас, шаланд галын аюулын Ш3 (хэвийн шатдаг) ангиллаас илүүгүй ангиллын материалуудыг хэрэглэнэ.				
Барилгын бүсүүдэд үүргийн галын аюулын хувьд тавих шаардлагууд						
24	Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх /БНБД 31-22-21/-ийн 7-р зүйл 7.1.3	7.1.3 А төрлийн тасгуудыг бусад хэсгүүдээсээ гал эсэргүүцэх 2-р төрлөөс багагүй хана, 3-р төрлөөс (1-р зэргийн гал тэсвэрлэх барилгад 2-р төрлөөс) багагүй				

<p>хучилтаар тусгаарлагдсан тусдаа блок эсвэл барилгын хэсэгт байрлуулна. /БНБД 21-01-021-р хүснэгт /</p>				
<p>Гал тэсвэрлэх II, 111-р зэргийн барилгуудад галд тэсвэрлэх 2-р төрлийн хана ба 3-р төрлийн хучилт төлөвлөх ба хонгил болон дамжих гонхонд гал түймрийн үед даралттай агаар өгөхөөр төлөвлөнө. Ингэсэн тохиолдолд дээр дурдсан тасгууд нь нэг давхарт байрласан бол 2-р төрлийн галд тэсвэрлэх ханын оронд 1-р төрлийн галд тэсвэрлэх хамар хана төлөвлөж болно. /БНБД 21-01-02-ын 1-р хүснэгт</p>				
<p>Б ба Е төрлийн тасгууд А төрлийн тасгуудтай нэг галын бүслэвчид байрлах бол тэдгээрийг гал эсэргүүцэх 2-р төрлөөс багагүй ханаар (1-р төрлийн хамар ханаар) ба 3-р төрлөөс багагүй (1-р зэргийн гал тэсвэрлэх барилгад 2-р төрлийн) хучилтаар тусгаарлагдсан байна. /БНБД 21-01-021-р хүснэгт /</p>				
<p>А төрлийн тасгуудтай барилгад буй эмчилгээний биеийн тамирын танхим, хурлын танхим, хоолны газар зэрэг 50-иас илүү хүнтэй өрөө, тасалгаануудыг гал эсэргүүцэх 1-р төрлийн хамар хана ба 3-р төрлийн хучилтаар тусгаарлаж, объектын зарлан мэдээлэх ба нүүлгэн шилжүүлэлтийг удирдах систем тавина /БНБД-21-04-05//1-р хүснэгт /</p>				
<p>Саун болон дулааны эмчилгээний байр, өрөө (хэт улаан туяанаас бусад) тасалгааг 50-иас илүү хүн байдаг өрөө, тасалгаануудын болон өвчтөнүүдийн өрөөний доор, мөн А ба Б төрлийн тасгуудтай барилгын зоорийн</p>				

25

26

27

28

		давхарт төлөвлөхгүй.				
29		Б төрлийн барилгуудад байрлах Е төрлийн тасгуудын В4 ба Д ангиллын өрөө тасалгааг галаас хамгаалах 2-р төрлийн хамар ханаар тусгаарлана. /БНБД 21-01-02-ын 5.5, 5.7/				
30		Б төрлийн барилгуудад байрлах Е төрлийн тасгуудын В4 ба Д ангиллын өрөө тасалгааг галаас хамгаалах 2-р төрлийн хамар ханаар тусгаарлана. /БНБД 21-01-02-ын 5.5, 5.7/				
31		Барилга дотор 50м ² -аас ихгүй талбайтай, өвчтөнүүд, ар гэрийнхэн болон ажиллагсдад зориулсан хоолны болон мухлагийн худалдааны газрыг гал эсэргүүцэх хамар ханаар тусгаарлахгүйгээр төлөвлөж болно. Төлбөр хийх автомат (мөнгөний АТМ, ус, ундаа худалдаалах автомат машин) төхөөрөмжүүдийг галын аюултай, авралтын зам гарцын бүсэд байрлуулж болохгүй бөгөөд тэдгээр нь нүүлгэн шилжүүлэх замд саад болох ёсгүй.				
32		Гал эсэргүүцэх ханан дахь нээлхийн дүүргэлтийн (хаалганы) материалын гал тэсвэрлэх хязгаарыг БНБД 21-01-02-ын хүснэгт 2-ын дагуу төлөвлөнө.				
33		Түргэн тусламжийн машин эмнэлгийн барилга руу орох технологийн шаардлагатай өрөөнүүдийг гал эсэргүүцэх 2-р төрлийн хана ба 1-р төрлийн хучилтаар (БНБД 21-01-02-ын хүснэгт) тусгаарлана.				
		Шат ба дамжих гонхууд				
7.1.5 Цахилгаан шат ба өргүүрүүд						

34		Галын бүслэвчийн хилийг давсан цахилгаан шат ба өргүүрүүдийн босоо хонгил, түүнчлэн кабелийн холболтын сувгууд, босоо хонгилууд ба нүхнүүдийн хаших хийц нь галд тэсвэрлэх хязгаар KE1 150-иас багагүй байна. Эдгээр хийцүүдийн нүхний дүүргэгчийн гал тэсвэрлэх хязгаар E! 60-аас багагүй байх ёстой.				
35	Эмнэлэгийн зориулалттай барилга төлөвлөх /БНБД 31-22-21/-ийн 7-р зүйл 7.1.5	Шатны хонгилын гадна талд байрлах цахилгаан шатны хонгил ба цахилгаан шатны машины өрөөний хаших хийцийг (дээвэр дээрхээс бусад) болон шугам сүлжээ явах хонгилыг гал эсэргүүцэх 1-р төрлийн хамар хана, 3-р төрлийн хучилтад тавигдах шаардлагын дагуу төлөвлөнө. Цахилгаан шатны хонгил ба машины өрөөний хоорондох хаших хийцийн гал тэсвэрлэх хязгаар E15-аас багагүй байна. /БНБД 21-01-02 2-р хүснэгт/				
36		Цахилгаан шатны хонгилоос эмнэлгийн хонгил болон бусад өрөө рүү гарах (шатны хонгилоос бусад) хаалганд E1 30-аас багагүй гал тэсвэрлэх хязгаартай гал эсэргүүцэх хаалга, эсвэл гал түймрийн үед автоматаар хаагддаг E1 45-аас багагүй гал тэсвэрлэх хязгаартай галаас хамгаалах хаалт төлөвлөх буюу цахилгаан шатны хонгилыг барилгын хонгил, шат ба бусад өрөөнөөс гал эсэргүүцэх 1-р төрлийн хамар хана, 3-р төрлийн хучилт бүхий гонх, дамжих хүзүүвчээр тусгаарласан байна.				
37		А төрлийн тасгуудтай галын бүс бүрд эмнэлгийн цахилгаан шаттай ижил хэмжээтэй галын мэргэжлийн хүмүүст зориулсан цахилгаан				

		шат төлөвлөнө.				
38	Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх /БНБД 31-22-21/-ийн 7-р зүйл 7.2	Гал түймрийн үед хүмүүсийн аврах, аюулгүй нүүлгэн шилжүүлэхийг хангасан эсэх				

Тайлбар: Хяналт шалгалтын хуудсанд давхацсан асуултыг харьяалах хуулийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

<i>Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>
<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>
<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>

ТАЙЛБАР:

.....

.....

.....